



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

“ МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ ” ТӨХК

2023 ОНЫ I УЛИРЛЫН ХУДАЛДАН АВАЛТАНД
ХИЙСЭН ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН
[Ажлын баримт: 3002-1]

УЛААНБААТАР ХОТ

2023.05.24

1. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

ЗОРИЛГО: Компанийн бизнесийн үйл ажиллагааг хангахын тулд төрийн болон орон нутгийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавихад дотоод аудитын зорилго оршино. Худалдан авах гэрээний биелэлт, чанарыг хараат бус бодитой байдлаар үнэлж, холбогдох дүгнэлт, зөвлөмж өгөн, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах замаар, төрийн болон орон нутгийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг, үр нөлөөг сайжруулахад чиглэнэ.

Хугацаа: 2023 оны 1-р улирал

Аудитын объект нэгж: Санхүү, эдийн засгийн газар, Захиргаа удирдлагын газар – Худалдан авалт, хангамжийн алба

Дотоод аудитын ажлын хүрээ:

- ТБОНӨХБАҮХА тухай хууль, МУ Сангийн сайдын 2017 оны 365 дугаар тушаал “Худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх журам, “МТЗ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаал “Худалдан авах ажиллагааны журам”-ын хэрэгжилт, 2023 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдан авалт хийсэн эсэх
 - Хөрөнгө оруулалт, худалдан авалтын тендерийг tender.gov.mn сайтаар зарласан эсэх, үнэлгээ үнэн зөв бодитой, бичиг баримт бүрэн эсэх, гэрээний биелэлт чанартай эсэхэд үнэлгээ өгөх
 - Үр ашиг, үр нөлөөг сайжруулах зөвлөмж, дүгнэлт өгөх
- Дараах горимоор хөрөнгө оруулалт, худалдан авалтын үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.
- 01-03 дугаар саруудын худалдан авалтын тайланг худалдан авалт хариуцсан мэргэжилтнээр сар бүрийн 10-ны дотор гаргуулан авах;
 - Худалдан авалтуудыг болон мөнгөн хөрөнгийн дансны гүйлгээтэй тулгаж үзэх;
 - Мөнгөн хөрөнгийн тайлангаас худалдан авалтын төлбөрийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг шалгах;
 - Хөрөнгө оруулалт, худалдан авалтын гэрээний биелэлт, чанар, бодитой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - Тайлан бичих;

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ

2023 оны 03 дугаар сарын 31 ны байдлаарх гүйцэтгэл

Санхүүжилтийн эх үүсвэр: Өөрийн хөрөнгөөр					
№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг (мян.төг)	Гэрээний дүн	Гүйцэтгэл	Хувь
1	2	3	6	7	8
Хөрөнгө оруулалтын шинж чанартай					
1	Notebook	20,399,800	15,530,480	15,530,480	76,1
2	НББ программ хангамж	71,522,000	38,696,900	38,696,900	54%
3	Вирусны программын лиценз	5,800,000	2,780,000	2,780,000	48%
4	Гагнуурын аппарат /380В/	4,000,000	704,000	704,000	17.6%
	Хэсгийн дүн				

Зардлын шинж чанартай худалдан авалт

Урсгал төсөв					
1	GC-220K мотовозын сэлбэг хэрэгсэл	103,580,000	19,000,000	19,000,000	18.3%
2	Тээврийн хэрэгслий даатгал	30,000,000	29,890,020	29,890,020	99%
3	Домкрат	20,000,000	20,000,000	20,000,000	100%
4	Түлш	21,676,618,575.8		1,556,600,000	7%
5	Хүнс /мах /			210,996,100	
ДҮН					

Нөхцөл байдал: Худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилтийн явц дараах үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд “Монголын төмөр зам” ТӨХК-д

- **Нээлттэй тендер шалгаруулалт / НТШ / :** 1-р улиралд нээлттэй тендер шалгаруулалт зарласан боловч шалгаруулалтын хугацаа дуусаагүй, гэрээ хийгдээгүй байна. 2023 онд Тендерээр худалдан авах бараа, ажил үйлчилгээ, сэлбэг материалын жагсаалтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд /tender.gov.mn/ байршуулсан байна. Дараах өмнөх онд тендерт шалгарч гэрээ хийгдсэн компаниудын гэрээнд дараагийн бүтээгдэхүүн нийлүүлэх байгууллагатай гэрээ байгуулах хугацаанд хүчин төгөлдөр байна гэж заасан байгаа тул үргэлжлүүлэн худалдан авалтуудыг хийж ирсэн байна. Үүнд:

1. Түлшний худалдан авалтыг НИК ХХК-тай

1. Хүнс / Мах Цогтцэций өртөө / худалдан авалтыг Мон С Энд С ХХК -тай

2. Хүнс / Мах Төмөртэй өртөө / худалдан авалтыг Арцат алтай уулс ХХК-тай тус тус хийсэн байна. Худалдан авалтын мэдээллүүд шилэн дансны 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зарлагын гүйлгээний мэдээлэлд орсон байна.

№	Бараа, ажил үйлчилгээ, тоо хэмжээ	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гүйцэтгэлийн байдал	Нийцлийн зөрчил байгаа эсэх
1	Түлш			1,556,600,000	үгүй
2	Хүнс /мах /			210,996,100	үгүй
	НИЙТ ДҮН				

- **Харьцуулалтын аргаар /ХА/:** 1 худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.1.1 д заасан босго үнийн дээд хязгаарыг зөрчөөгүй 34.1.3. заалтыг үндэслэн худалдан авалт хийсэн байна. Үүнд:

- **5. ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР ХИЙГДСЭН ХУДАЛДАН АВАЛТ**

№	Бараа, ажил үйлчилгээ, тоо хэмжээ	Гэрээний дүн	Гүйцэтгэлийн байдал	Нийцлийн зөрчил байгаа эсэх
1	Сэлбэг, тос	236,530,000	70,959,000	үгүй
2				үгүй
	НИЙТ ДҮН			

- **Шууд худалдан авалтаар /ШХА/:** Шууд худалдан авалтууд нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.1.1 д заасан босго үнийн дээд хязгаарыг зөрчөөгүй байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 20.0 сая төгрөгөөс доош үнийн дүнтэй хөрөнгө, зардлын шинж чанартай бага үнийн дүнтэй худалдан авалтууд хийгдсэн байна. Төсөв батлуулан батлагдсан төсвийн дагуу худалдан авалт хийгдсэн байгаа боловч зарим ажил гүйцэтгэх гэрээнд ажлын үнийн дүнг ерөнхий байдлаар тоймлон гэрээ байгуулж / дотор засварын ажил / хийгдсэн байна. Мөн зарим худалдан авалтууд худалдан авалт, хангамжийн албаар дамжиж хийгдээгүй байна.

Үүнд: 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалтуудыг оруулав.

№	Бараа, ажил үйлчилгээ, тоо хэмжээ	Гэрээний дүн	Гүйцэтгэлийн байдал	Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх	Нийцлийн зөрчил байгаа эсэх
1	Ухаалаг дэлгэц	19,700,000	19,700,000	үгүй	үгүй
2	Ус цэвэршүүлэгч	15,961,000	15,961,000	үгүй	үгүй
3	Хово чиргүүлийн засвар	13,028,400	13,028,400	үгүй	үгүй

4	Хүнсний материал	14,020,685	14,020,685	үгүй	үгүй
5	Засвар үйлчилгээ	10,450,000	10,450,000	үгүй	үгүй
6	Цахилгаан материал	14,902,800	14,902,800	үгүй	үгүй
7	Хүнсний материал	14,733,160	14,733,160	үгүй	үгүй
8	Нүүрс	14,300,000	14,300,000	үгүй	үгүй
9	Балласт цэвэрлэгчийн голны резьба	15,840,000	15,840,000	үгүй	үгүй
10	Нүүрс	20,020,000	20,020,000	үгүй	үгүй
11	Засвар үйлчилгээ	14,410,000	14,410,000	үгүй	үгүй
12	Сэлбэг	19,778,000	19,778,000	үгүй	үгүй
13	Сэлбэг	19,999,936	19,999,936	үгүй	үгүй

ДҮГНЭЛТ

- 1-3 дугаар сарын худалдан авалтын тайланд худалдан авсан бараа материал, ажил үйлчилгээ, хөрөнгийг бүрэн тусгаж тайлагнаагүй байна. Тайланд ороогүй худалдан авалтууд худалдан авалт, хангамжийн албаар дамжуулж хийгдээгүй байна. Энэ нь худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу хийх, хяналт тавих, худалдан авалтын тайлан гарахад хүндрэлтэй байдал бий болгож байна.
- Худалдан авалтын анхан шатны баримтын бүрдэл хангагдсан гэж үзэж байна.
- Оффисын “А” хурлын өрөө болон хойд талын үүдний хэсгийн засварын ажлыг гэрээгээр хийлгэхдээ хийлгэх ажлын үнэлгээ, төсвийг нэг бүрчлэн гаргалгүй багц ажил болгон тооцож хийлгэсэн нь Гүйцэтгэх захирлын А/57 тушаалаар баталсан Монголын төмөр зам ТӨХК-ийн “Худалдан авах ажиллагааны журмын” 2.17 заалт / журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгох ба төсөвт өртөгт багтаан ААН, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулахдаа Санхүүгийн бүтцийн нэгж болон Гүйцэтгэх захиралд танилцуулж баталгаажуулна / заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Төмөртэй өртөө, Цогтцэций өртөөнд ачуулж явуулсан бараа материал, хөрөнгийг хариуцсан няравт хүлээн авсан актын дагуу хүлээлгэн өгөөгүй, нягтлан бодох бүртгэлийн албанд мэдэгдээгүй тохиолдол гарсан байна. / худалдан авсан тос тосолгооны материал /

ЗӨВЛӨМЖ

1. Бараа материал, хөрөнгө, ажил, үйлчилгээний худалдан авалтыг Худалдан авалт хангамжийн албатай хамтарч, захиалга өгч хийлгэж, худалдан авалт хийж байхыг бүх газрын ахлах менежер, менежер нарт
2. 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн А/57 тоот тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны журмын 2.37-д / Худалдан авалтын төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтийг худалдан авалт хариуцсан албан тушаалтан зохих журмын дагуу улирал тутам тайлан гаргана/ заасны дагуу улирлын тайлан гаргаж байхыг Худалдан авалт хангамжийн албаны менежерт
3. Худалдан авалт хийсэн бараа материал, сэлбэг, хөрөнгийг бүрэн бүтэн, баримтын дагуу, актаар хүлээн авч хариуцсан няравт хүлээлгэн өгч баримтжуулах, нягтлан бодогчид мэдэгдэж байхыг Худалдан авалтын мэргэжилтэнд
4. Төмөртэй өртөө, Цогтцэций өртөөнд худалдан авсан, тээвэрлэлтээр хүргүүлж байгаа бараа материал, сэлбэг хэрэгсэл, хөрөнгийн мэдээллийг СЭЗГ-ын НББ-ийн албанд мэдэгдэж бүрэн бүтэн хүлээн авсан эсэхэд хяналт тавьж ажиллахыг Худалдан авалтын мэргэжилтэнд
5. Сар бүрийн худалдан авалтын тайланд тухайн сар худалдан авсан бараа материал, сэлбэг хэрэгсэл, хөрөнгө, ажил, үйлчилгээг бүрэн тусгаж тайлагнаж байхыг тус тус зөвлөмж болгож байна

ТАНИЛЦСАН: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ МЕНЕЖЕР

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН

П.ГАНХҮҮ

Б.ЛХАГВАСҮРЭН

Б.БАДАМДОРЖ

УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН
ТӨМӨР ЗАМ
ТӨХИ

111630377

0214203 СТА3294